



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/22/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Халхгол хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204

Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.04 № 168

танай _____-ны № _____-т

ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.АРИУНСУВД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520198



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайддын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Ариунсүвд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 27-ноос 2020 оны 03 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/43 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, холбогдох баримт материалыг 02 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн.



2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”-д оршино.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Халхгол сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ахplorer” программ хангамж ашигладаг байна.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Халхгол сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитын төлөвлөлтийн үе шатанд 20 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 794,324.9 мянган төгрөгөөс тооцон 15,776.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,046.0 мянган төгрөгөөр тооцсон нь зардлын гүйцэтгэл өмнөх оноос өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,914,511.4 мянган төгрөгөөр буюу 519,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	20,475.9	15,200.0	-5,275.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	250,217.5	265,388.0	15,170.5
Үндсэн хөрөнгө	3,355,730.1	13,489,427.8	10,133,697.7
Хуримтлагдсан элэгдэл	-1,263,160.9	-1,492,241.6	-229,080.7
Нийт хөрөнгө	2,363,262.6	12,277,774.2	9,914,511.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2.363.262.6	12.277.774.2	9,914,511.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2.363.262.6	12.277.774.2	9,914,511.6

Авлага дансны үлдэгдэл буурсан өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.



Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материалд 627.5 мянган төгрөгийн, бичиг хэргийн 75.0 мянган төгрөгийн, аж ахуйн 55,351.8 мянган, бусад хангамжийн 3,750.0 мянган, 205,583.7 мянган төгрөгийн мал амьтад байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь “Шинэ сум” төсөл хэрэгжсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,567,476.4 мянган төгрөгийн барилга байгууламж, 8,275,377.6 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн байгууламж, аймгийн хөрөнгө оруулалтаар 9,990.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 215,590.4 мянган төгрөгийн бусад хөрөнгө, сумын хөрөнгө оруулалтаар 9591.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,500.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 76,443.3 мянган төгрөгийн бусад хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 932,2 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авснаар нэмэгдсэн байна

Биет бус хөрөнгө өссөн нь 932,2 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн буурсан асуудал байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,277,774.2 мянган төгрөг болж 9,914,511.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад өмнөх оны 1,800.0 төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 469,629.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 469,629.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 469,629.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: ОБГ-аас өмнөх оны шүлхий өвчний хохирлын зардалд 14,129.4 мянган төгрөг, ХХААГ-аас үлийн цагаан оготно устгалд 14,320.0 мянган төгрөг, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 94,538.7 мянган төгрөг, шилдэг сумын шагналд 1,500.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 342.2 мянган төгрөг, Батлан хамгаалах яамнаас ойн арга хэмжээний зардалд 40,000.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас шинэ сумын нээлтэд зориулан 5,000.0 мянган төгрөг, Байгаль орчны газраас байгаль хамгаалах үйл ажиллагаанд 425.5 мянган төгрөгийн санхүүжилт өгч, өөрийн орлогын 2,223.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нийт 172,479.4 мянган төгрөгөөр нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.



Олгосон санхүүжилтүүдийг зориулалтын дагуу бүрэн зарцуулж, 2,223.6 мянган төгрөгийн өөрийн орлогоос бий болсон эх үүсвэрийг Тамгын газрын гэрэл цахилгаан, бичиг хэрэг, ном худалдан авахад зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 20 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 317,811.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 45,523.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,219.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 251,918.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 18,219.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 254,138.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс 2,219.3 мянган төгрөгийг төслийн шатахуун болон сургалт уралдаан тэмцээний шагналд зарцуулсан байна. Энэ нь Энэ нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-д хамаарахгүй, мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 155,667.0 мянган төгрөгийн цаашид ашиглагдахгүй үр ашиггүй хөрөнгө /сумын дэд бүтцийг сайжруулах болон дулаан, цэвэр, бохир усны зураг төсөл/ байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Шатахууныг батлагдсан төсвийн хүрээнд, ЗГ-аас тогтоосон норм нормативын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад, жолоочийн замын хуудсанд спидометрийн заалт байхгүй, тооцоо бодоогүй, нэг албан тушаалтан нэг өдөр 3 өөр машинаар 3-4 өөр зүгт зэрэг явснаар бичигдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. ...", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



4. Данс бүртгэлд тусгагдсан Ланд круйзер 200 маркийн 00-94УНД улсын дугаартай тээврийн хэрэгсэл "Хэт" ХХК-ий нэр дээр бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Тус газар тайлант онд 51,463.8 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд аргаар хийсэн байна. Энэ нь ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн шууд худалдан авалтын хязгаараас давсан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" 8 дугаар зүйлийн 8.4 дэх "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

6. Жилийн эцсийн санхүүгийн тайланг 2020.01.27нд ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1. " ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ..." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах санал хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 18,219.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Халхгол сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 10,9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.



2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шатахууны данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч болон Тамгын газрын дарга нар тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр албан тушаалын суудлын автомашин хэрэглэн 18,219.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	270693320,00	280588012,00
33	АВЛАГА	20475860,00	15200000,00
335	Бусад авлага	20475860,00	15200000,00
3351	Байгууллагаас авах авлага	20475860,00	15200000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	250217460,00	265388012,00
351	Түүхий эд материал	427500,00	627500,00
35110	Тусгай зориулалттай материал	427500,00	627500,00
354	Хангамжийн материал	44206242,00	59176794,00
35410	Бичиг хэргийн материал	0,00	75000,00
35420	Аж ахуйн материал	40656242,00	55351794,00
35470	Бусад хангамжийн материал	350000,00	375000,00
35600	Мал амьтад	205583718,00	205583718,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2092569265,00	11997186233,27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2092569265,00	11997186233,27
392	Биет хөрөнгө	1955403506,71	11868075881,71
39201	Барилга, байгууламж, орон сууц	957036979,06	2534503357,03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-96165143,18	-131329673,66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149396082,00	149396082,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115650415,31	-124899548,64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207155562,51	188154164,11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99784577,34	-85433582,08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129365702,33	137008947,33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58982486,99	-74742080,87
39209	Зам, гүүрийн байгууламж	306496880,00	306496880,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-140183543,54	-153880642,58
39214	Бусад үндсэн хөрөнгө	1426171675,00	9993583015,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-709453207,83	-870781035,93
393	Биет бус хөрөнгө	137165758,29	129110351,56
39301	Програм хангамж	172956050,00	173134200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-42941491,71	-51175048,44
39303	Бусад биет бус хөрөнгө	7151200,00	7151200,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2363262585,00	12277774245,27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2363262585,00	12277774245,26
51	Засгийн газрын хувь оролцоо	2363262585,00	12277774245,26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1421673069,39	1421673069,39
51101	Өмч: - төрийн	1421673069,39	1421673069,39
512	Хуримтлагдсан үр дүн	267385790,89	10181897451,15
51210	Өмнөх үеийн үр дүн	302117259,92	265585790,89
51220	Тайлант үеийн үр дүн	-34731469,03	9916311660,26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	674203724,72	674203724,72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2363262585,00	12277774245,27



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	854305820,00	10718613183,97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151900200,00	10076504431,97
120	Нийтлэг татварын бус орлого	151900200,00	10076504431,97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	151900200,00	10076504431,97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	151900200,00	10076504431,97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702405620,00	642108752,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	615194200,00	469629300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	615194200,00	469629300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87211420,00	172479452,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51494150,00	19129422,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23998270,00	151126433,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11719000,00	2223597,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	870163588,15	802301523,71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	794324988,15	802301523,71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	794324988,15	784320331,71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208732288,00	225731879,00
210101	Үндсэн цалин	208732288,00	221683879,00
210104	Урамшуулал	0,00	4048000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24566704,00	27687948,00
210201	Тэтгэврийн даатгал	15362804,00	19020701,74
210202	Тэтгэмжийн даатгал	2263400,00	2237729,67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1878100,00	1739138,33
210204	Ажилгүйдлийн даатгал	460200,00	426398,02
210205	Эрүүл мэндийн даатгал	4602200,00	4263980,24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23006860,00	20230651,00
210301	Гэрэл, цахилгаан	4250000,00	6900397,00
210302	Түлш, халаалт	18756860,00	13330254,00
2104	Хангамж, бараа материалын зардал	85878015,00	60141947,00
210401	Бичиг хэрэг	3112000,00	3415100,00
210402	Тээвэр, шатахуун	66546015,00	51463847,00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	14350000,00	4760000,00
210404	Ном, хэвлэл	370000,00	503000,00
2105	Нормативт зардал	1800000,00	300000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1800000,00	300000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2801390,00	11235610,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0,00	228010,00
210604	Урсгал засвар	2801390,00	11007600,00
2107	Томилолт, зочны зардал	9500000,00	26341000,00
210702	Дотоод албан томилолт	9500000,00	16341000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0,00	10000000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2143290,00	946000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	420000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	459850,00	248300,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0,00	132000,00
210807	Газрын төлбөр	87440,00	145700,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	410683931,15	411705296,71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150921270,00	152420447,01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	259762661,15	259284849,70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0,00	17981192,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0,00	17981192,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0,00	17981192,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-15857768,15	9916311660,26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-34731469,03	9916311660,26



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	702405620,00	642108752,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702405620,00	642108752,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	615194200,00	469629300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	615194200,00	469629300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87211420,00	172479452,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51494150,00	19129422,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23998270,00	151126433,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11719000,00	2223597,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	554371120,00	642108752,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554371120,00	642108752,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554371120,00	624127560,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212141081,00	219208967,00
210101	Үндсэн цалин	212141081,00	215160967,00
210104	Урамшуулал	0,00	4048000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24566704,00	30735000,00
210201	Тэтгэврийн даатгал	15362804,00	20489800,00
210202	Тэтгэмжийн даатгал	2263400,00	2561300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1878100,00	2049000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	460200,00	512300,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4602200,00	5122600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21222000,00	21523897,00
210301	Гэрэл, цахилгаан	4250000,00	6900397,00
210302	Түлш, халаалт	16972000,00	14623500,00
2104	Хангамж, бараа материалын зардал	88062875,00	61216947,00
210401	Бичиг хэрэг	3112000,00	3490100,00
210402	Тээвэр, шатахуун	68330875,00	51463847,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14750000,00	5760000,00
210404	Ном, хэвлэл	370000,00	503000,00
2105	Нормативт зардал	1800000,00	300000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1800000,00	300000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44013900,00	29744600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1500000,00	9684000,00
210602	Тавилга	11000000,00	8500000,00
210604	Урсгал засвар	31513900,00	11560600,00
2107	Томилолт, зочны зардал	9500000,00	26341000,00
210702	Дотоод албан томилолт	9500000,00	16341000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0,00	10000000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2143290,00	1878200,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	420000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	459850,00	248300,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0,00	132000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200000,00	932200,00
210807	Газрын төлбөр	87440,00	145700,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150921270,00	233178949,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150921270,00	233178949,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0,00	17981192,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0,00	17981192,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0,00	17981192,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0,00	0,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0,00	0,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	0,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	0,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	463 471 010,64	2 559 347 804,75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	-161 353 750,72	-161 353 750,72
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	302 117 259,92	2 397 994 054,03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	-34 731 469,03	-34 731 469,03
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	267 385 790,89	2 363 262 585,00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	267 385 790,89	2 363 262 585,00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	-1 800 000,00	-1 800 000,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	265 585 790,89	2 361 462 585,00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	9 916 311 660,26	9 916 311 660,26
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 421 673 069,39	674 203 724,72	10 181 897 451,15	12 277 774 245,26



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470129300,00	451648108,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470129300,00	451648108,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470129300,00	451648108,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232925000,00	215160967,00
210101	Үндсэн цалин	232925000,00	215160967,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30735000,00	30735000,00
210201	Тэтгэврийн даатгал	20489800,00	20489800,00
210202	Тэтгэмжийн даатгал	2561300,00	2561300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2049000,00	2049000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	512300,00	512300,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5122600,00	5122600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19256300,00	19756300,00
210301	Гэрэл, цахилгаан	4632800,00	5132800,00
210302	Түлш, халаалт	14623500,00	14623500,00
2104	Хангамж, бараа материалын зардал	58908200,00	58908200,00
210401	Бичиг хэрэг	3034100,00	3034100,00
210402	Тээвэр, шатахуун	49611100,00	49611100,00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	5760000,00	5760000,00
210404	Ном, хэвлэл	503000,00	503000,00
2105	Нормативт зардал	300000,00	300000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000,00	300000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29142600,00	29142600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9082000,00	9082000,00
210602	Тавилга	8500000,00	8500000,00
210604	Урсгал засвар	11560600,00	11560600,00
2107	Томилолт, зочны зардал	25444000,00	25444000,00
210702	Дотоод албан томилолт	15444000,00	15444000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10000000,00	10000000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1878200,00	1878200,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420000,00	420000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248300,00	248300,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132000,00	132000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932200,00	932200,00
210807	Газрын төлбөр	145700,00	145700,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71540000,00	70322841,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71540000,00	70322841,00